


НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНООС 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны 05 дугаар сарын 27

Улаанбаатар хот

№	ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ			
1	Хорооны хуралдаан	<p>Ёс зүйн хэсгийн хорооны хурлаар дараах асуудлуудыг авч хэлэлцэв. Ёс зүйн хэсгийн хорооноос хийсэн хурлын тоо - 2 Авч хэлэлцсэн асуудал -3, 100% шийдвэрлэв. Нийт шийдвэрлэсэн асуудлын тоо - 2 Үүнээс: 2026 оны төлөвлөгөө - 1</p> <ol style="list-style-type: none"> 1. ЭМЯ-ны шагналд нэр дэвшигчдийн ёс зүйн дүгнэлт 2. Зэргийн шалгалтад нэр дэвшигчдийн ёс зүйн дүгнэлт 3. Ёс зүйн хэсгийн хороонд ирсэн <p>Нийт 0 гомдол.</p>			
2	<p>Ёс зүйн талаар сургалт</p> <p>Ёс зүйн аяны хүрэнд "Харилцан Адилгүй зан төлөвийг удирдах, үйлчлүүлэгчид анхны сэтгэгдлийг зөргөөр төрүүлэх сэдэвт сургалтыг Хан-уул салбарын эмч нарт Soft skills сургагч багш С.Буян-орших эмчийг урьж зохион байгуулав. Сургалтад дасгал ажил ажиллаж, бүлгийн ярилцлага хийв.</p>  <p>Дуудлага хүлээн авах нэгжийн нийт эмч сувилагч нарт "Эмнэлгийн ажилчдын ёс зүйн хэм хэмжээ" сэдэвт цахим сургалтыг зохион байгуулсан.</p>	<p>Эмч эмнэлгийн дээд мэргэжилтэн</p> <p>- 15</p> <p>- 6</p>	<p>Эмнэлгийн тусгай мэргэжилтэн</p> <p>- 3</p> <p>- 12</p>	<p>Бусад эмнэлгийн мэргэжилтэй ажилчид</p> <p>- 2</p>	<p>Иргэд</p>

<p>Эрүүл мэндийн сайдын А/406 тоот “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” тушаалыг эмч нарт танилцуулан, цаашид ёс зүйн зөрчилтэй холбоотой алдаа, гомдол гаргахаас сэргийлж сургалт зохион байгуулсан.</p>		- 30	- 8	- 2		
						
<p>Ажлын байр нь дээрх ёс зүйтэй харилцааг төлөвшүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</p>			- 15	- 5	- 2	
<p>“Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг үлгэрлэх нь” сэдэвт сургалтыг ажлын байран дээрээ зохион байгуулсан</p>		- 31	- 3	- 2		
		40	10			

“Ажлын байр нь дээр ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ” сэдэвт сургалт, семинарт 2026 оны 03 дугаар сарын 09-нд захиргааны болон эмч сувилагч нар нийт 50 буюу 100% хамрагдсан.

№	Ажлын байр	Хүний тоо	Хамрагдсан тоо
1
2
3
4
5
6
7
8
9
10
11
12
13
14
15
16
17
18
19
20
21
22
23
24
25
26
27
28
29
30
31
32
33
34
35
36
37
38
39
40
41
42
43
44
45
46
47
48
49
50

№	Ажлын байр	Хүний тоо	Хамрагдсан тоо
12
13
14
15
16
17
18
19
20

Уж. Д.СЭДЭВТ СЭРГЭЛТ ЭХЛЭХ ҮЕД МЭДЛЭГ 25%



Нийслэлийн 12-р цэцэрлэгийн багш, ажилчдад “Хахалтын үеийн яаралтай тусламж, амилуулах суурь тусламж”, “ЭМС-ын 406-р тушаал, Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг” сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 66 багш ажилчид хамрагдсан. Сургалтын үр дүн сургалт эхлэх үед мэдлэг 25% байсан сургалт дуусах үед 88% болсон үр дүнтэй хийсэн.



<p>ХУД–ийн 5-р хорооны иргэдэд Угаарын хийн “хордлогын үед авах арга хэмжээ” ,“Амьлуулах суурь тусламж” ,“ЭМС-ын 406-р тушаал, Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг” сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулж,гэрээр сурталчилгааны тараах материал тараасан.</p> <p>Сургалтад нийт 30өрхийн иргэд хамрагдсан.</p> <p>Сургалтын үр дүн: С ургалт эхлэх үеийн өмнөх үнэлгээ20 ,%сургалтын дараах үнэлгээ 93%.</p>  <p>Мөн Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406-р “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” тушаалын хүрээнд “Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг”-ийг сурталчлан таниулж сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. Нийт120 өрх хамрагдсан.</p> <p>“Ахмад настнуудад эрүүл мэндийн боловсрол олгох”, “Ямар үед түргэн тусламж дуудаж болох” талаар сургалт орж үзлэг хийсэн. Тус сургалтад нийт 85 ахмад настан оролцсоноос 50 ахмад настанд нь үзлэг хийж зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” тушаалын хүрээнд “Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг”-ийг сурталчлан таниулж сургалт, сурталчилгааг зохион байгуулсан.</p> <p>Сургалтын үр дүнд:</p>	- 6	- 6		- 120
				- 50

Ахмад настнууд анхан шатны эрүүл мэндийн мэдлэгтэй болж, АД хянах, АД бууруулах эмийн хэрэглээг зохистой хэрэглэх, мөн ямар үед яаралтай түргэн тусламж дуудаж болох, үйлчлүүлэгчийн ёс зүйн тушаалын талаар мэдлэг, мэдээ мэдээлэлтэй болсон.





- 25


ДХАННэгжтэй холбоотой ёс зүй харьцаа хандлагатай гомдлыг бууруулахаар "Ёс зүйн дүрэм журмууд" сэдвийн хүрээнд МУЭМС-ын А/406 дугаар тушаал 2019.09.04-ны өдрийн "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай", МУЭМС-ын А/319 дугаар тушаал 2022.06.16-ны өдрийн "Сувилахуйн мэргэжилтний Ёс зүйн дүрэм", Монгол улсын засгийн газрын тогтоол 2024.10.02-ны өдрийн "Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай" 109-р тогтоол, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" Монгол Улсын Хууль 2023.05.04-ны өдрийн "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулиудын хүрээнд мэдээлэл бэлдэж, сургалт орсон. Сургалтын өмнөх болон дараах сорил авсан.



	<p>Ёс зүй харилцаа хандлагын сургалтыг 4 удаа зохион байгуулж 25 ажилтныг хамруулсан. Үүнд: "Ёс зүйн холбогдох тушаалууд", "ЭМС-ын 406 2019.09.04 "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай", "МУЗГ-ын 2024 оны 10-р сарын 02-ны өдрийн "Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай" 109-р тогтоол "сэдэвт сургалтыг 2026 оны 02-р сар, 4-р сард төв салбарын сургалтын өрөөнд зохион байгуулсан. Сургалтын өмнөх үнэлгээ 21%-65%, сургалтын дараах үнэлгээ 70%-85.3%. Сургалтын ирц 100%.</p>				
3	<p>Ёс зүйн асуудлаар зохион байгуулсан үйл ажиллагаа</p>	<ol style="list-style-type: none"> 1. Нийт 5 салбараас ёс зүйн хэсгийн хороог шинэчлэхээр санал авсан. 2. Байгууллагын вэб сайт, салбаруудын мэдээллийн самбарт мэдээллүүдийг байршуулсан. 3. "Ёс зүйн зөрчлийг үл тэвчье" 2 сарын аян зохион байгуулсан. Түргэн тусламжийн үйл ажиллагааг сурталчлах эрүүл мэндийн зөвлөгөө өгч гарын авлага, рийл, контент хийж иргэдэд мэдээлэл өгсөн. 4. ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, эмч ажилчдын харьцаа хандлага, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор "Ёс зүйтэй харилцааг өөрөөсөө, хамт олноосоо эхэлье" аяныг зарлаж, удирдамж, хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан байгууллагын даргаар батлуулан, хэрэгжүүлж ажилласан. 5. Шинээр ажилд орж байгаа ажилтнуудад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн ЭМС-ын А/406-р тушаал, байгууллагын дотоод хэм хэмжээ, байгууллагаас мөрдөгдөж байгаа үйл ажиллагааны журам, хууль тогтоомж уншуулж гарын үсгээр баталгаажуулсан. 6. 2026 оны эхний 6 сарын байдлаар нийт 15 шинэ эмч нарт дээрх тушаал зааврыг танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан. 7. "Ёс зүй, тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг" сэдэвт хэлэлцүүлэгийг ХДХАНэгж дээр 2 удаа зохион байгуулсан. Үүнд: 			

		<p>Тохиолдолд суурилсан хэлэлцүүлгийг “Дуудлага хүлээн авах нэгдсэн нэгж”-ийн 1, 2, 3-р ээлжийн эмч, сувилагч нарт 2026 оны 03-р сарын 04-06-ий хооронд танхимаар, 04-р сарын 29-нд зүүмээр ЭМТҮЧАБА-тай хамтран ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, ёс зүйн тушаал, хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, багаар ажиллах чадварыг чадавхжуулах, хувь хүний харьцаа хандлагыг сайруулах, ёс зүй харьцаа хандлагатай холбоотой гомдол дахин гаргахаас сэргийлж 2 удаа зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 2025 он, 2026 оны эхний 4 сард гарсан ДХАННэгжтэй холбоотой гомдлуудыг танилцуулж, хэрхэн дахин алдаа гаргахгүй байх талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд 2026 онд ДХАННэгжтэй холбоотой ёс зүй харьцаа хандлагатай гомдлыг бууруулах, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр “Ёс зүйн дүрэм журмууд” сэдвийн хүрээнд МУЭМС-ын А/406 дугаар тушаал 2019.09.04-ны өдрийн “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай”, МУЭМС-ын 2025 оны 05-р сарын 01-ны өдрийн А/174 дүгээр тушаал “Журам шинэчлэн батлах тухай”, МУЭМС-ын А/319 дугаар тушаал 2022.06.16-ны өдрийн “Сувилахуйн мэргэжилтний Ёс зүйн дүрэм”, Монгол улсын засгийн газрын тогтоол 2024.10.02-ны өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109-р тогтоол, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” Монгол Улсын Хууль 2023.05.04-ны өдрийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулиудын хүрээнд мэдээлэл бэлдэж, “Ёс зүй, эерэг хандлага, эерэг сэтгэл хөдлөл” сэдэвт сургалт орсон. Сургалтын өмнөх болон дараах сорил авсан.</p> <p>Үр дүн:</p> <p>“Дуудлага хүлээн авах нэгдсэн нэгж”-ийн эмч, сувилагч нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлж, ёс зүйтэй холбоотой гомдол, эрсдэл гарахаас сэргийлсэн үр дүнтэй хэлэлцүүлэг, сургалт болсон.</p>
--	--	--

													
4	Эвлэрүүлэн зуучлалын хийсэн	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн тоо 0	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн 0	Үйлчлүүлэгч эмнэлийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн тоо 0	Ёс зүй харьцаа хандлагын гомдол гараагүй тул эвлэрүүлэн зуучлалын хийгдээгүй болно								
5	Ил тод байдал	<p>Цахим хуудсанд байршуулсан ёс зүйн үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл</p> <ol style="list-style-type: none"> 2026 оны төлөвлөгөөг байршуулсан. Ёс зүйн аяны хүрээнд хийгдсэн ажлуудыг байршуулсан. Эмч ажилчдад ирсэн нийт талархлыг 14 хоног тутам 18 удаа вэб сайтад байршуулсан. <p>2026 оны эхний хагас жилийн байдлаар талархал давхардсан тоогоор 175 эмч, ахлах эмч, 111 жолооч, 1 сувилагч нарын давхардсан тоогоор 443 талархал ирсэн байна.</p> <p>Талархал авсан ажилчдын улирлын ажил дүгнэх үзүүлэлт оруулж урамшуулал олгосон. Ирсэн талархлыг вэб сайтад байршуулсан.</p> <div data-bbox="1339 1157 1825 1396">  <table border="1"> <thead> <tr> <th>Ажилчдын төрөл</th> <th>Талархал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Эмч, Ахлах эмч</td> <td>175</td> </tr> <tr> <td>Жолооч</td> <td>111</td> </tr> <tr> <td>Сувилагч</td> <td>1</td> </tr> </tbody> </table> </div>				Ажилчдын төрөл	Талархал	Эмч, Ахлах эмч	175	Жолооч	111	Сувилагч	1
Ажилчдын төрөл	Талархал												
Эмч, Ахлах эмч	175												
Жолооч	111												
Сувилагч	1												

6	Бусад ажил	<p>1. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” аяныг 2025 оны 10 дугаар сарын 23-аас 2026 оны 01-р сарын 13-ны өдөр хүртэл хугацаанд амжилттай зохион байгуулсан. “Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” аян зохион байгуулах тухай байгууллагын даргын А/75 дугаар тушаал гарч, тушаалын хүрээнд удирдамж, төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шагнал урамшууллыг тушаалаар баталж, Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, хэрэгжүүлэн ажилласан.</p>  <p>2. Байгууллагын даргын А/75 дугаар тушаалын хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн аяны үр дүнг дүгнэж, ахлах эмч 3, дуудлагын эмч 3, оператор эмч, сувилагч, эмийн санч 3, жолооч 3, захиргаа, инженер техникийн ажилтан, аж ахуйн ажилтан 3, нийт 15 ажилтныг шалгаруулж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, урамшуулсан. Тайланг 2026.01.14-нд НЭМГ-т хүргүүлсэн. Үүнд: Байгууллагын хэмжээнд “Ёс зүйтэй харилцааг өөрөөсөө, хамт олноосоо эхэлье” 2 сарын аяны уриа гаргасан. Аяны хүрээнд салбар, ээлж тус бүр уриа гаргаж идэвхтэй оролцсон. Үүнд: Хан-Уул салбарын уриа “НЭГ ЗҮРХ, НЭГ ХАМТ ОЛОН”, Чингэлтэй салбарын уриа “НЭГ ДУУДЛАГА, НЭГ АМЬДРАЛ, НЭГ ҮЙЛДЭЛ, НЭГ ИТГЭЛ”, Баян-зүрх салбарын уриа “ЭЕРЭГ ХАНДЛАГА, ӨӨРИЙМСӨГ СЭТГЭЛ, ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАЖ, ТАНД ҮЙЛЧИЛНЭ”, Сонгино хайрхан салбарын уриа “ЗӨВХӨН БИ ХАНДЛАГЫГ ӨӨРЧИЛЖ, ХАМТЫН СОЁЛЫГ БҮТЭЭЭ”, Төв салбарын уриа “ЭЕЛДЭГ ХАРЬЦАА, ЭЕРЭГ ХАНДЛАГА”, Хүүхдийг дуудлага хүлээн авах нэгдсэн нэгжийн уриа “ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭЭ-ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙГ БҮТЭЭЭ”, Захиргаа, автобаазын уриа ““ЗӨВ СЭТГЭЛГЭЭГ БИД, ЗӨВ АЛХМЫГ ТА” Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын</p>
---	------------	--

албанаас “ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙ” уриатайгаар байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлж, харилцаа хандлага, ажлын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүй, сахилга хариуцлагаар манлайлагч нарыг тодруулах, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилготойгоор салбарын ээлж хамт олон төлөвлөгөө гарган, салбарын эмч нарын телеграмм группэд байрлуулан ажилласан. Цахим орчинд болон салбар ээлж хамт олон дотроо бүгд уриагаа хэлж, байршуулсан. /Facebook, Instagram-д хуваалцав/



Ёс зүйн аяны хүрээнд ажлын хувцсаа бүрэн өмсөж, зохих журмын дагуу энгэрийн тэмдгээ бүрэн зүүж хэвшсэн. Дуудлагын эмч нарын хувцаслалт, энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн байдал:



Жолооч нарын хувцаслалт, энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн байдал



энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн байдал:



Үр дүн:

Үйлчлүүлэгч, ар гэрийнхэнд итгэл төрүүлэхээс гадна эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, халдварын эрсдэлээс сэргийлсэн. Мэндлэх ёс зүй, харилцаа хандлага, биеэ авч явж буй соёлыг байгууллагын ажилтан бүр эрхэмлэн ажиллаж байна. Ажлын байран дээр болон бусад үед эелдэг харилцааг эрхэмлэн гомдол, саналгүй ажилласан. Хамт олны дунд дулаан уур амьсгал бүрдүүлэх зорилгоор өөрсдийн зургаар анимэшион, хүүхэлдэйн баатрын дүр болгон хувиргаж сүлд модоо чимсэн.



“Түргэн тусламжийн эмч, жолооч нартаа хайрыг түгээцгээе” рийл видео хийж цахим пэйждээ байршуулсан. Видеог түргэн тусламжийн баримтат киноноос хэсэгчлэн авч, үйлчлүүлэгч биед халддаг, эрсдэлийн талаар оруулж түргэн тусламжийн эмч жолооч нарын бодит байдлыг харуулсан контентыг эвлүүлж байршуулсан. Хандалтын тоо 1100 лайк, 247 шейр хийгдсэн байна.



Цахим орчинд /Facebook, Instagram / иргэдэд зориулсан богино хэмжээний зохиомж бичлэг байршуулан хамгийн олон лайк /143/, шейр /22/ хандалттай байна. Frame хийлгэж бэлтгэн зохион байгуулсан Дуудлагын ачаалал багасгах /томуугийн/, яаралтай дуудлага болон хөнгөн өөрсдөө эмнэлэг явах боломжтой дуудлагыг иргэд олон нийтэд таниулах зорилгоор иргэдэд чиглэсэн контент бүтээж, сурталчилсан.



Манай оронд жил бүр улиралтай холбоотойгоор томуугийн өвчлөл 10-11-р сард ихэсдэг. Энэхүү өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хамгийн энгийн арга нь гар угаах, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчээр гараа халдваргүйжүүлэх, агаарын сэлгэцэл хийх, дархлаа дэмжих, маск зүүх арга. Иймээс иргэдэд “Томуугийн өвчлөл, халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэх арга” сэдвийн хүрээнд

иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилготойгоор богино хэмжээний видеог зохион бүтээж, сурталчилсан.



14,8k үзлэлтэй, like - нийт5241 share - 325



8k үзлэлтэй, like - нийт2804 share - 137



“Subdaa studio”-р дамжуулан байгууллага, ажлын онцлогоо сурталчлан олон нийтэд мэдээлэл хүргэж, шууд дамжуулсан.



share 30 Like-112 үзэлт – 5000 давсан.

Үзэлт нийтshare 35, Like-128, үзэлт – 9000 давсан comment - бүгд эерэг байв.



Нийслэлийн түргэн тусламжийн төвийн ажлын онцлогийг танилцуулж иргэдэд анхан шатны ямар тусламж үзүүлэх талаар видео бичлэг хийж, иргэдэд сурталчилсан.



Жүжигчин Өскөтэй хамтарсан “Иргэдийг соён гэгээрүүлэх” рийл.
 “Тусламж үйлчилгээнд гарахад жолооч нар ажлын байрны бэлтгэлийг хэрхэн хангадаг талаар” рийл хийсэн.
 “Ажлын хувцаслалт хэрхэн зөв, цэвэрхэн өмсөх санамж”
 “Таны зам тавьж өгсөн нэг хором нэг зүрхэнд амьдрал бэлэглэдэг. Зам тавьж өгсөнд баярлалаа” сэдэвт 60 ширхэг хуулга хийж дуудлагын автомашинуудад наасан.



Ахмад жолооч нарын ажлын талаарх сэтгэгдэл, дурсамж хуваалцсан бичлэгүүдийг авто баазын группт байршуулсан. “Үгээрээ биш, үйлдлээрээ үлгэрлэе, хүндэлье” уриатай ажлын байран дээрх ёс зүйг харуулсан рийл хийж, телеграмм болон фэйсбүүкт байршуулсан.

Министрийн Тусгай Тусламжийн Төв
Албан Фони Хуудас
...
Ёс зүйтэй харилцааг өөрөсөө, яамт олноосоо
Эхлээд
Харилцааг салбарын 1 эвдлийн яамт Апп



“Дуудлагын эмч, жолоочийн нэг өдрийн үйл ажиллагаа” сэдэвт ажлын байраа сурталчлах, үйлчлүүлэгчийн ёс зүй ямар байх ёстой талаар мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор ажлын байран дээрх нэг өдрийн влог хийж, фэйсбүүк болон инстеграмм хуудсанд нийтэлж ажилласан.

Үүний үр дүнд цахим орчинд оруулсан рийл нь нийт 35,000 үзэлт хүрч, мэдээ мэдээлэл нь цахим орчинд түгээгдсэн.



Үйлчлүүлэгчдээс түргэн тусламжийн үйлчилгээний чанар, харилцаа хандлагын 8 асуултыг ГҮҮГЛ форм дээр боловсруулж, эмч нарт QR код болгон илгээж үнэлгээг хийсээр байна.

Асуултыг дурдвал:

Дуудлагаар ирсэн эмч тантай мэндэлсэн үү?

Эмч танд үзлэг хийхдээ гараа халдваргүйжүүлсэн үү?

Эмч таны үзлэг, эмчилгээний талаар ойлгомжтойгоор тайлбарлаж чиглүүлж өгсөн үү?

Дуудлагын эмчийн гардан үйлдлийн ур чадварыг үнэлнэ үү

Эмчилгээтэй холбоотой гарч болох хүндрэл, гаж нөлөөний талаар хэлж анхааруулсан уу ?

Түргэн тусламжийн төвийн эмч тантай боловсон харьцсан уу ?

Энэ удаад түргэн тусламжийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна ?

Нийслэлийн түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулахад юунд анхаарах шаардлагатай талаар та саналаа бичнэ үү .



Нийт ээлжийн эмч ажилчдын дунд 4 төрлийн асуулга бүхий хүснэгтээр /flip chart /үнэлгээ хийж хамгийн олон эможи авсан “Хамгийн хамгийн ёс зүйтэй эрүүл мэндийн ажилтан” эмч, сувилагч нарыг шалгаруулсан.





Ахлах эмч, хамтран ажилладаг эмч нараас судалгаа, үнэлгээ авах зорилгоор 5 салбарт саналын хайрцаг аялууулсан.



Байгууллагын нийт ажилчдадаа ТАЛАРХЛЫН ЗАХИДЛЫГ цахим хаягаар 100% илгээсэн.



Ажилтан бүрийн сэтгэл ханамж 100%, ажилчид өөрийн цахим хуудсандаа пост оруулах, стори оруулах хэлбэрээр талархлаа илэрхийлсэн.



Ёс зүйн талаарх хууль, дүрэм журам, талархал, сар бүрийн манлайлагчдыг тодруулах зорилгоор "Ёс зүйн булан"-г санаачилж автобааз дээр байрлуулсан. Самбарын мэдээллийг сар бүр шинэчилнэ. Самбарын үнэ-150.000 төгрөг. Ажилчдаас 100%-ийн үнэлгээ авсан. Ажлын байрны уур амьсгалыг эерэг болгох, хамт олонч байдлыг дэмжих "ЭЭРЭГ ӨГЛӨӨ" бэлгийн сугалааг сугалуулж, гарын бэлэгтэй өглөөг угтсан үйл ажиллагааг зохион байгуулсан. Урам өгөх үгсийг хүн бүрд өөрөөр бичиж 23 төрлийн бэлгийг бэлдэж / Төсөв – 70к/ сугалааг бэлдсэн.



Дуудлага хүлээн авах нэгжийн эмч сувилагч нарт дуудлага бүртгэл, мэдээлэл үнэн зөв авах хурдан шуурхай үйлчлэх хаягийн мэдлэгийг сайжруулах зорилготой GMAP /google/ IMAP, I track зэрэг программуудыг ашиглан ажлын байр нь дээрх дадлага сургалтыг шинээр санаачлан амжилттай, зохион байгуулсан. Байгууллагын 125 жолооч тус бүр хувийн ариун цэврийн булантай болсон. Нийт 1.250.000 төгрөг



“Аз уу ёондоо юу, эерэг харилцаа, инээмсэглэлийг танд” ажлыг ажилчдын дунд зохион байгуулсан.



Салбарын эмч, жолооч нарын дунд “Аэтан сугалаа” зохион байгуулсан.

ТҮК болон цагдаа нарт аарц, маск бэлэглэсэн.



2025 оны 12 дугаар сарын 01–ний өдөр тусламж үйлчилгээнд ажиллаж байгаа байгууллагын бүх ажилтан нарт жолооч нар санаачлан халуун аарц, булочка өгсөн.



Өдөр бүр “Нэг эшлэл” аян зарлаж, өглөө ажилдаа ирэхдээ үүдэнд нааж, наасан эшлэлээ уншиж урам зориг, ажлын эрч хүч авлаа.



Иргэдийн боловсролыг дэмжих, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, үйлчлүүлэгчийн үүргийг олон нийтэд таниулах эмнэлгийн ажилчинтай хүндэтгэлтэй харилцах хүрээнд цахим орчинд бичлэг видео бэлтгэн байршуулсан. Лайк 64, шэйр 34 хандалт авсан байна.



“Угаарын хийн хордлого, урьдчилан сэргийлэх нь” сэдвээр мэдээлэл хүргэв. /1,3к үзэлттэй,12 хуваалцсан байна. Мэдээлэл хүргэснээр иргэд угаарын хордлогын шинж тэмдгийг таних, урьдчилан сэргийлж өртөхөөс сэргийлэх ач холбогдолтой.



“Хүүхдийн амьсгалын замын өвчлөл”-ийн талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. 344 үзэлт, лайк, 26 сэтгэгдэл, 215 хуваалцсан байна.

Сүбээдэй суваг цахим хуудсанд “Цаг үеийн байдал, томуугийн өвчлөл, урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 2 удаагийн ярилцлага өгсөн.



Байгууллагын цахим хуудас болон эмч нарын iPad-ын дэлгэцэд эрүүл мэндийн сайдын А/406 тоот тушаалын 2 дугаар хавсралтын үйлчлүүлэгчийн үүрэг хэсгийг постер хэлбэрээр бэлтгэж байршуулж ажигласан.



Цахим орчин /Facebook ,Instagram/-д QR код бэлтгэн цахим орчинд байршуулав.Эмнэлгийн ажилчид гар утсаа ашиглан хаанаас, хэзээ ч хамрагдах боломжтой юм.



“Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” 2 сарын аяны хүрээнд байгууллагын ажилтан бүр ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлж, засгийн газрын 1111-ээс нийт 81 талархал авч, хамт олонч уур амьсгалыг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, иргэдэд эрүүл мэндийн боловсролыг түгээн дэлгэрүүллээ.

Өдөр бүхэн хамт олонч эерэг харилцаа, хандлага, инээмсэглэлийг өөртөө болон хамтран ажиглагсад, үйлчлүүлэгчдэд түгээж, ёс зүй эв эе, сахилга хариуцлагаар хамт олноо үлгэрлэсэн эрүүл мэндийн ажилтан, байгууллагын соёлыг хэвшүүлж байна.

Ажилтан бүр хамт олноо эергээр үлгэрлэж, эмнэлгийн мэргэжилтэн өөр хоорондын, эмнэлгийн мэргэжилтэн-үйлчлүүлэгч хоорондын харилцаа сайжирч, ажлын үр дүн, үнэлэмж дээшилсэн.

		<p>Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, иргэд хоорондын итгэлцэл, хүндлэл бий болж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан.</p> <p>Ажилтнуудын ёс зүйн мэдлэг, хандлага сайжирч, байгууллагын дотоод уур амьсгалд эерэг өөрчлөлт гарсан.</p> <p>Ажлын цаг барилт, дүрэмт хувцсыг иж бүрэн өмсөж 100% хэвшсэн.</p> <p>Тусламж үйлчилгээнд ажиллаж байгаа автомашинууддаа санамж, стикер байршуулж, хувцаслаптаараа жигдэрч, ёс зүйн булан байгуулан, салбар бүрд саналын хайрцаг аялуулан инженер техникийн алба болон жолооч нарын талаарх саналыг авч дүгнэлээ.</p> <p>Ёс зүйн буланд хууль, хэм хэмжээ, талархал, өмнөх сарын манлайлагчид, энэ сарын үзүүлэлт жолооч бүрийн нэрээр нийтэд ил тод байрлуулж өдөр тутам тэмдэглэл хөтөллөө.</p> <p>Ёс зүйн аяны хүрээнд ёс зүйн чиглэлээр төлөвлөсөн олон талт ажлуудыг зохих түвшинд хэрэгжүүлж, байгууллагын ёс зүйн соёл, хариуцлага сайжирч бодит үр дүн гарсан гэж дүгнэсэн.</p>
--	--	--

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:
ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ ДАРГА


Д.ДАРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН:
ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


С.АКЕРКЕ